

# Ковид-19-ийн шинжилгээнд хамрагдах нь

## Хэн шинжилгээнд хамрагдах ёстой вэ?

Ханиадтай төстэй дор дурдсан шинж тэмдэг бүхий хэн ч гэсэн, тэрхүү шинж тэмдэг хичнээн ялихгүй байлаа ч гэсэн, та Ковид-19-ийн шинжилгээнд аль болох хурдан хамрагдвал зохино:

- Халуурах /даарах, шөнийн цагаар хөлрөх гэх мэт/
- Ханиалгах, хоолой хөндүүрлэх/загатнах, амьсгал давчдах, үнэр болон амт мэдрэхгүй болох гэх мэт амьсгалын замын өвчний шинж тэмдгүүд
- Биеийн булчин болон үеэр хөндүүрлэх, толгой эргэх/бөөлжих, суулгах, эсвэл хоол идэх дуршилгүй болох гэх мэт шинж тэмдгүүд

## Шинжилгээ өгөхдөө мэдэж байвал зохих зүйлс юу вэ?

- Шинжилгээ үнэ төлбөргүй
- Таныг шинжилгээнд хамрагд гэж бичиг өгсөн бол түүнийгээ авчраарай. Гэхдээ ихэнх эмнэлгүүд тийм бичиг шаардахгүй.
- Эмнэлгийн ажилтнууд хамгаалалтын маск, хувцас, бээлий, нүүрний хамгаалалт хийж хамгаалагдсан байх болно.
- Эмнэлгийн ажилтнууд өвчний ямар шинж тэмдгүүд илэрч байгаа талаар тань танаас асуух болно.
- Таны хамар болон хоолойноос арчдас авах замаар шинжилгээ авах болно.

## Шинжилгээ өгсөний дараа юу болох вэ?

- Та шинжилгээний хариу сөрөг гартал гэрээсээ гарахгүй байх (өөрийгөө тусгаарлах).
- Эмнэлгийн тусламж хэрэгтэй болсон эсвэл маш онцгой аюулт нөхцөл байдал үүсээгүй л бол та гэртээ үлдэх ёстой.
- Хэрэв таны биеийн байдал муудвал (жишээлбэл амьсгалж чадахгүй болох гэх мэт) түргэн тусламжийн 000-д дуудлага өгөөрөй. Түргэний эмчид та өөрийгөө Ковид-19-ийн шинжилгээ өгсөн гэдгээ хэлэх ёстой.
- Хэрэв та гэртээ бусадтай хамт амьдардаг бол та өөрийгөө тусдаа өрөөнд тусгаарлах хэрэгтэй. Бусадтай нэг өрөөнд байх бол маск зүүж 1.5 метрийн зай барих шаардлагатай.

- Хувийн ариун цэврийг чандлан сахиж гараа тогтмол угаана уу. Ханиах болон найтаахдаа амаа гараараа эсвэл тохойгоороо халхална уу.

## Өөрийгөө тусгаарлах талаар нэмэлт мэдээллийг би хаанаас авч болох вэ?

<https://www.health.nsw.gov.au/Infectious/covid-19/Pages/resources.aspx>

- Ковид-19-тэй хүнтэй ойр хавьталд орсон бол та тэр хүнтэй хамгийн сүүлд уулзсанаасаа хойшхи 14 хоногт та гэртээ байх ёстой. (Ойрын хавьтал гэдэгт Ковид-19-өөр өвчилсөн хүнтэй тэр хүнийг халдвар аваад 48 цаг болохынх нь өмнө та тэр хүнтэй нэг гэрт амьдарсан, эсвэл нүүр нүүрээрээ тулж 15 минутаас илүү удаан хугацаагаар ярилцсан, эсвэл битүү байранд 2 цагаас илүү хугацаанд хамт байсан).
- Таны бие сайн байгаа, эсвэл шинжилгээний хариу сөрөг гарсан ч байлаа гэсэн та хэрвээ ойр хавьталд орсон бол заавал өөрийгөө гэртээ тусгаарлах хэрэгтэй.

## Би шинжилгээний хариугаа хэрхэн авах вэ?

- Шинжилгээний хариу ихэнхдээ 24-48 цагийн дотор гардаг, гэхдээ та 72 цаг болж магадгүй гэж тооцоорой.
- Та шинжилгээгээ улсын Ковид-19-ийн эмнэлэгт юм уу түргэн тусламжийн тасагт байхдаа өгсөн бол мөн та Ковид-19-ийн текст мессежийн үйлчилгээнд утсаа бүртгүүлсэн бол, шинжилгээний хариу тань таны утсанд мессежээр ирэх болно. Хэрэв тийм биш бол орон нутгийн эрүүл мэндийн хэлтсийн ажилтан тантай утсаар ярьж мэдэгдэх болно.
- Хэрэв таны шинжилгээний хариу таны өрхийн эмчид юм уу өөр эмнэлэгт очих бол тухайн эмч танд хариу тань өгөх болно.

## Шинжилгээний дүн эерэг гарвал би яах вэ?

- Шинэ Өмнөд Уэлс мужын эрүүл мэндийн яам танд санаа тавих болно. Таны Медикер картгүй байлаа ч таны эмчилгээ үнэ төлбөргүй байх болно.

Ковид-19-ийн  
шинжилгээнд хамрагдах нь**Би хаана шинжилгээ өгч болох вэ?**

- Ковид-19-ын эмнэлгүүдийг доорх холбоосоор орон олж болно:  
<https://www.health.nsw.gov.au/Infectious/covid-19/Pages/clinics.aspx>  
ЭСВЭЛ
- Өөрийн өрхийн эмчтэйгээ холбогдоорой

**Шинэ Өмнөд Уэлс мужын эрүүл мэндийн яамны харьяа Ковид-19-ийн шинжилгээний төвүүд:**

Дүүрэг	Байршил	Ажиллах цагууд	Утас	Өрхийн эмчийн бичиг хэрэгтэй юу?